



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 06 сарын 17 өдөр

дугаар 205

Улаанбаатар 407

Гадаадад суралцуулах тухай

2002-2003 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 182 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төрболд овогтой Бат-Оргилыг АНУ-ын Колумбын Их сургуулиас АНУ-ын Рэдфордын Их сургуулийн бизнесийн удирдлагын магистрантурт шилжүүлэн суралцуулахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчийн гэрээг сунгаж, сүүлийн хагас жилийн сургалтын зардлыг АНУ-ын Рэдфордын Их сургууль руу шилжүүлэхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



САЙД

*[Handwritten signature]*  
А.ЦАНЖИД